



**ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 14 өдөр

Дугаар A/64

Өмнөдэлгэр сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалтыг үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.2025 оны төсвийн орлого бүрдүүлэх, өр барагдуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Татварын улсын байцаагч

Гишүүн: “Хэнтий шинэс” сум
дундын ойн ангийн дарга

Багийн Засаг дарга нар

Байгаль орчны хяналтын улсын байцаагч

Газрын даамал

2.Ажлын хэсэгт шаардлагатай шатахууныг олгохыг санхүү албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч (Б.Гантулга)-д зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн A/48 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.



Р.ЭНХТӨР

